



## БАЯНЛИГ СУМЫН АРДЧИЛСАН НАМЫН 2020-2024 ОНЫ МӨРИЙН ХӨТӨЛБӨР

Хөтөлбөрийн уриа: Хүн бүрд орлого,өрх бүрд өсөлт

Нэг. Хүртээмжтэй эдийн засгийг дэмжин, тогтвортой өсөлтийг хангах,үйлдвэржүүлэх бодлого.

1.1. Баянлиг сумын нийгэм эдийн засгийг хөгжүүлэх 2021-2031 оны мастер төлөвлөгөөг боловсруулах.

1.2. Шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх гарааны бизнесийг дэмжин сумын онцлогтой мэдлэг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлэх.

1.3. “Баянлигт үйлдвэрлэв” үйлдвэрлэв бүтээгдэхүүнийг сүм аймагт болон хотуудад худалдааны сүлжээнд холбох.

1.4. Суманд түүхий эдийн анхан шатны боловруулалт хийх төвүүд байгуулхын зэрэгцээ арьс, нэхий , ноос, хөөвөр сүлжмэл нэхмэлийн болон оёдлын цех байгуулж үйл ажиллагааг дэмжин ажиллах.

1.5. Нийгэм, эдийн засгийн хөгжлөөрөө бус нутагтаа тэргүүлэгч сумдуудтай өрсөлдсөн, аймгийн хэмжээнд тэргүүлэх сүм болно.

**Хоёр. Хувь хүний хөгжил, эрх чөлөө**

### 2.1. Боловсрол

2.1.1. Багш, сурагчдын сурч, хөгжих орчныг сайжруулж, хүүхдэд ээлтэй сургалтын орчинг бүрдүүлэн, сурагчдад мэргэжлийн чиг баримжаа олгон, төлөвшүүлэх хөтөлбөр хэрэгжүүлнэ.

2.1.2. Багшлах боловсон хүчинд тавих шаардлагыг өндөрсгөж, тэдний мэргэжлийн болон багшлах ур чадварыг дээшлүүлэх,боловсролын салбарт ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

2.1.3. Сумдын сургууль цэцэрлэг, соёлын төвүүдийг шаардлагатай техник тоног төхөөрөмжөөр үе шаттай хангаж ажиллана.

2.1.4. Анги дэвших төгсөх болон хөндлөнгийн шалгалтын үнэлгээгээр хариуцсан ангия 60 аас дээш хувийн гүйцэтгэлтэй шалгагдсан бага ангийн багш нарыг урамшуулдаг тогтолцоог бий болгоно.Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 100 хувьд хүргэж, нэг багшид ногдох хүүхдийн тоог 25 хүртэл бууруулна

2.1.5. Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг 100 хувьд хүргэж, нэг багшид ногдох хүүхдийн тоог 25 хүртэл бууруулна.

000000001

2.1.6. Жил бүр тодорхой тооны залуучуудыг сонгон шалгаруулж, гадаадын болон дотоодын нэр хүндтэй **АРДЧИЛСАН НАМ** сургуулиудын тэтэгэлэгт сургалтанд хамруулж, гэрээгээр сургахад дэмжиж ажиллана.

2.1.7. Сургууль, эцэг эх, төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг бэхжүүлж, боловсролын салбарын үйл ажиллагааг дэмжсэн хөрөнгө оруулалт хийсэн иргэд ААН, байгууллагуудыг бодлогоор дэмжинэ.

2.1.8. Боловсрол, соёл, урлагийн салбарын гадаад харилцааг хөгжүүлж, жил бүр багш, удирдах ажилтнуудыг гадаадад мэргэжил дээшлүүлэх сургалт, танилцах аялалд хамруулах.

2.1.9. Түүх, урлаг, соёлын үнэт өвүүд, алдартай хүмүүсийн бүтээлийн үзэсгэлэнг жил бүр аймгийнхаа “Соёл, урлагийн их наадам” –д оролцуулна.

## 2.2. Эрүүл мэнд

2.2.1. Нийгмийн эрүүл мэндийн боловсролыг байнга дээшлүүлж, иргэдийг жил бүр урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээнд хамруулан, шаардлагатай хүмүүсийг дараагийн шатны үзлэг, оношилгоо, эмчилгээнд хамруулж хэвшинэ.

2.2.2. Эрүүл мэндийн салбарын ажилтнууд, мэргэжилтнүүдийн мэргэжил, боловсролын тасралтгүй дээшлүүлэх сургалт семинарт хамруулах.

2.2.3. Эрүүл мэндийн салбарын удирдлагын менежментийг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.2.4. Эрүүл мэндийн байгууллагуудыг нэн шаардлагатай орчин үеийн техник, тоног төхөөрөмжөөр эн тэргүүнд хангах.

2.2.5. Эрүүл мэндийн салбарын эмч ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх бодлогын хүрээнд “Орон сууц” хөтөлбөрт хөнгөлөлттэй нөхцөлөөр ээлж дараатай хамруулах.

2.2.6. Эх, нялхсын эндэгдлийг аймгийн /2016-2025 он/ хөгжлийн бодлогын баримт бичигт заасан түвшинд хүртэл бууруулна..

2.2.7. Эмийн сангийн менежментийг боловсронгуй болгож, хувийн хэвшлийн хэлбэрээр хөгжүүлж, эм, эмнэлгийн хэрэгслийн чанартай ханган нийлүүлэлт, үнийн уян хатан бодлого хэрэгжүүлнэ.

2.2.8. Уламжлалт анагаах ухааны чиглэлээр эрэлт хэрэгцээнд нийцсэн өрсөлдөх чадвар сайтай хувийн хэвшлийн эмнэлгийг хөгжүүлэх

## 2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих

2.3.1. Иргэдээ ажилтай орлоготой өрхийг өсөлттэй болгох замаар ажилгүйдлийг бууруулах, Үр ашигтай жижиг дунд үйлдвэрлэлийг орон нутгийн бодлогоор дэмжиж, төв суурингийн өрх бүрээс 1 хүнийг тогтвортой ажлын байртай байлгах бодлого хэрэгжүүлнэ.

2.3.2. Өрхийн үйлдвэрлэлийн өсөлтийг бүх талаар дэмжиж, бага оврын дэвшилтэт тоног төхөөрөмжийн мэдээллийг иргэдэд хүргэх, зуучлах, тоног төхөөрөмжийг түрээслэх, лизингийн зээлээр олгох үйлчилгээг хөгжүүлнэ.

2.3.3. Шинээр ажлын байр бий болгож нутгийн иргэдийг тогтвортой ажлын байраар хангасан ААН-үүдийг жил бүр шалгаруулж, тэдний үйл ажиллагааг дэмжиж урамшуулдаг тогтолцоог бий болгоно.

00000002

## **2.4. Нийгмийн хамгаалал.**

2.4.1. Зорилтот бүлгийг оновчтой тодорхойлж, тэдэнд чиглэсэн төрийн халамжийн бодлогыг хүртээмжтэй хүргэхийн зэрэгцээ тэдний ажил хөдөлмөр эрхлэх идэвхи санаачилга, боломжийг дэмжиж, хөгжүүлнэ.

2.4.2. Залуу гэр бүлийг эхний ээлжинд ажлын байр, хөнгөлөлттэй тохилог сууцанд хамруулах, оюутан залуусыг бодлогоор дэмжих бодлого баримтална.

### **Гурав. Өрхийн өсөлтийг дэмжих ХАА**

#### **Өрхийн өсөлтийг тэтгэсэн Хөдөө аж ахуй**

##### **3.1. Мал аж ахуй**

3.1.1. . Мал сүргийг чанаржуулж, нэг малаас авах ашиг шимийг нэмэгдүүлж, малынхаа тоо толгойг бэлчээрийн даацаад тохируулах бодлогыг баримтална.

3.1.2. Ингэ, ямааны сүүг уламжлалт болон орчин үеийн технологиор боловсруулах жижиг дунд үйлдвэрийг байгуулан хөгжүүлнэ.

3.1.3. Сумын хонин сүрэгт Баяд үүлдрийг сайжруулагчаар ашиглаж, хонин толгойн амьдын жин, махны гарцыг нэмэгдүүлнэ.

3.1.4.“Залаажинстийн цагаан” ямааг сайжруулагчаар ашиглаж, ямааны нэгжээс ашиглах ноолуурын гарц, чанарыг тогтвортой түвшинд байлгах, сайжруулах.

3.1.5. “Малын эрсдэлийн сан”-г суманд байгуулан, бэлчээр хамгаалах, бэлчээрийн уст цэгийг нэмэгдүүлэх, цөлжилтийг бууруулах, хөв цөөрөм байгуулах, малын эрүүл мэндийг хамгаалах, үүлдэр угсааг сайжруулах арга хэмжээг тухайн сангийн хөрөнгөөр шийддэг байх орчинг бүрдүүлнэ.

3.1.6. Тэмээн сүрэгтээ Ханын хэцийн хүрэн, Галбын.govийн улаан үүлдрийн тэмээг сайжруулагчаар ашиглана.

3.1.7. Малын эрүүл мэндийг хамгаалахад анхаарч, малын эмч нарыг тогтвортууршилтай ажиллуулж, мал эрүүлжүүлэхэд шаардлагатай тоног төхөөрөмжийн хангамжийг сайжруулна.

##### **3..2. Газар тариалан:**

3.2.1. Сумын хүн амын төмс, хүнсний ногооны хэрэгцээг өөрийн сумын хөрсөнд тариалсан бүтээгдэхүүнээр хангахыг зорьж, хэрэгжүүлнэ.

3.2.2.“Цагаан будаа ” дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, тариалах санаачилгыг дэмжинэ.

3.2.3.Төмс, хүнсний ногооны 100 тн хүртэл багтаамжтай стандарт зоорь барьж ашиглах асуудлыг төсөл хөтөлбөрөөр шийдвэрлэнэ.

3.2.4.Тохиромжтой бүсүүдэд 4 улирлын ажиллагаатай хүлэмжийн тариалалтыг хөгжүүлэх.

3.2.5. Жил бүр мал аж ахуйн салбарын өвөлжилт хаваржилтын үеийн шаардлагатай хадлан тэжээлийг бэлтгэж, сумын хэрэгцээгээ хангадаг болно.

3.2.6. Төмс хүнсний ногоогоор нэмүү өртөг шингэсэн эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, энэ үйлдвэрлэлийг дэмжиж хөгжүүлэх

000000003

3.2.7. Лигийн голын услалтын системийн ашиглалтыг сайжруулж, усалгаатай газар тариалан эрхлэгчдийн үйл ажиллагааг дэмжинэ.

### 3.3. Тогтвортой байгаль орчин

3.3.1. Газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд тусгах замаар төв суурин газрын ногоон байгууламжийн хэмжээг одоогийн түвшингээс 2 дахин нэмэгдүүлж, эвдэрсэн газруудыг бүрэн нөхөн сэргээх ажлыг оновчтой зохион байгуулна.

3.3.2. Сумдаа хог хаягдлыг ангилан ялгах ажлыг зохион байгуулж, хог хаягдлыг дахин боловсруулах жижиг үйлдвэр байгуулах

3.3.43 Гол горхи, булаг шандны эх болон цөлжилт элсний нүүдэлд өртөж, хөрсний элэгдэлд орсон газруудад заг, сухай, хайлаас, буйлс, торлог зэрэг модлог ургамлуудыг тариалж, ногоон зурvas бий болгох.

3.3.4. Хөдөөгийн эвдэрсэн газруудыг бүрэн нөхөн сэргээх ажлыг оновчтой зохион байгуулна.

3.3.5. Нүүдлийн МАА-н соёл иргэншилд суурилсан нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг бодлогоор дэмжиж ажиллана.

## Дөрөв. Хуулиа дээдэлдэг, иргэддээ үйлчилдэг засаглал

### 4.1. Сайн засаглал

4.1.1. Засаг захиргааны бүх шатанд хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх чадвартай, авилгаас ангид байж, иргэндээ чанартай үйлчилгээ үзүүлдэг, хүнд сурталгүй, ил тод, хариуцлагатай Ухаалаг ардчилсан засаглалыг төлөвшүүлнэ.

4.1.2. Төрийн бүх байгууллагуудад орон тоо гарсан нөхцөлд олон нийт, хамт олны оролцоог хангасан, мэдлэг ур чадварт суурилсан нээлттэй сонгон шалгаруулалтаар сонгодог тогтолцоог дагаж мөрдөнө.

4.1.3. Иргэдээс төрийн алба, албан тушаалтантай холбоотой авлига, хээл хахууль, ашиг сонирхолын зөрчлийн талаар гаргасан мэдээллийг хүлээн авах цахим орчныг бүрдүүлж, түүний нууцыг хадгалж, мэдээллийн мөрөөр хяналт шалгалт хийж, хариуцлага тооцох зарчмыг нэвтрүүлнэ.

### 4.2. Төсөв санхүү

4.2.1. Төсвийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтаар сумын аж ахуйн нэгж, үйлдвэр эрхлэгчдийг дэмжих тогтолцоог бүрдүүлнэ.

4.2.2. Төсвийн зардлыг ач холбогдолоор нь эрэмбэлэх зарчимд шилжиж, алдагдлыг багасган хэмнэлтийн горимыг хэрэгжүүлж, аймгийн төсвийн чадавхийг нэмэгдүүлнэ.

4.2.3. Төсвийн ил тод байдлыг хангах шаардлагын дагуу Шилэн дансанд мэдээллийг тогтмол байршуулж, ил тод хяналттай төсвийг бий болгоно.

4.2.4. Баянлиг сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүд, салбар компаниудыг орон нутгийн татварын албанд бүртгэлтэй болгож, татварын орлогыг нэмэгдүүлэх

### 4.3. Дэд бүтэц, сум багийн хөгжил.

00000004  
D. Bayarjargal  
D. Bayarjargal

4.3.1. Сумд дэд бүтцийг нь бүрэн шийдсэн 30-50 айлын хувийн хаус хороолол, шинээр ашиглалтад оруулна.<sup>AM</sup>

4.3.2. Сумын төвийн гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд “Шинэ гудамж”, “Ногоон хороолол” төсөл хэрэгжүүлж, өрх бүр хашаандаа мод, хүнсний ногоо тариалж, орчноо ногооруулж, төрөөс дэд бүтэц, явган хүний зам, гэрэлтүүлэг, тоглоомын талбайг нь шийдвэрлэж жишиг гудамж бүхий ногоон суурингуудыг бий болгоно.

4.3.3. Багийн төвүүдийг шинэчлэх төслийг сэргээж, үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

**Тав. Аюулгүй, амгалан Баянлигчүүд**

**5.1. Гэмт хэрэг зөрчлийг бууруулах**

5.1.1. Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийг бууруулж “Архигүй Баянлигчүүд” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

5.1.2. Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг бүх шатанд эрчимжүүлж “Малын хулгайгүй сум” болохыг зорино.

**БАЯНЛИГ СУМЫН АРДЧИЛСАН НАМ**

000000005